



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар A/22

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/21 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабаас зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штаб, мэргэжлийн нэгжүүдийг шуурхай зохион байгуулалтад оруулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүрд танилцуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга бөгөөд Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабын орлогч дарга /М.Баяраа/-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Г.Ганхүү/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ